



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/90

Арвайхээр

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. БНХАУ-д гарсан шинэ коронавирусын халдвар (COVID-19)-ын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгасугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

3. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар өөрийн байгууллагадаа ухуулга, сурталчилгаа хийх, ажилтнуудын дархлааг дэмжих, амны хаалт хэрэглэх, гар угаах болон халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгаж, хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нарт уриалсугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай” А/55 дугаар захирамжийн 2 дахь заалтын баар, караоке, цэнгээний газрууд гэсний ард “компьютер тоглоом, спорт заал” гэж нэмсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газар (хурандаа Т.Мөнхдорж), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100191

D:My Doc. Zahirambj. Zasag darga